

ЗУДЫН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

*ДХИС-ийн ОБС-ийн Гамигаас хамгаалах албаны тэнхимийн профессор,
доктор (Ph.D), дэд хурандаа Ц.Ганчимэг
ДХИС-ийн магистрант, ахмад Х.Чүлтэмсүрэн*

Хураангуй: Зуд бол урьдчилан мэдэгдэхгүйгээр хэдэн минутын дотор томоохон газар нутгийг хамарч сүйрэл учруулдаг болон хүн амыг гэнэт цочирдуулж, амьд гарахад хэцүү байдалд оруулдаг тийм байгалийн гамшгийн төрөл биш юм. Харин ч эсрэгээр, зуд бол харьцангуй урьдчилан сэргийлэх боломжтой байгалийн үзэгдэл. Бэлтгэл, зохион байгуулалтын арга хэмжээг авах цаг хугацааг олгодог маш удаан үргэлжилдэг үйл явц...?, түүнийг даван туулах болон учруулах үр дагаврыг хязгаарлах арга замыг урьдчилан харах боломжтой гамшгийн төрөл юм¹⁰. Зудын гамшгаас урьдчилан сэргийлж бэлчээрийн чанар байдалд тохируулж малын тоо толгойг хязгаарлах, мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайн хангах, эрт зарлан мэдээллийн системийг үр дүнтэй зохион байгуулах, зохистой бөгөөд эрчимтэй хариу арга хэмжээний чадавхтай байснаар учирч болох муу үр дагавраас сэргийлж болно.

Түлхүүр үг: аюул, эмзэг байдал, чадавх

Монгол орны малчдын болон хөдөөгийн хүмүүсийн амьжиргаа нь мал аж ахуйгаас шууд хамааралтай байдаг. Хэдийгээр Монгол орны мал аж ахуйн салбар нь гол төлөв амьжиргааг залгуулахад чиглэгдсэн байдаг ч тэр нь маш олон өрхийн гол нэр төрлийн хэрэгцээг хангаж бусад зүйлүүдийг худалдан авах орлогыг бүрдүүлдэг. Хангалттай малгүйгээр, энэ хүмүүс амьдралын эх үүсвэрээ алдаж хоол хүнсний тусламжинд хамааралтай болж ядуурлын түвшин нэмэгддэг. Энэхүү мал аж ахуйн салбарын цочирол нь малын гаралтай

2024 оны 2 дугаар сарын 2 дугаар 10 хоногийн цасан бүрхүүлийн эзлэх хувь

Аймгийн нэр		Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан
Цасан бүрхүүлийн эзлэх хувь, %	Цастай	81	63	51	75	46	99	75	84	96	88	85
	Цасгүй	19	37	49	25	54	1	25	16	4	12	15
Аймгийн нэр		Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Улсын хэмжээнд
Цасан бүрхүүлийн эзлэх хувь, %	Цастай	94	67	23	100	68	89	88	54	75	83	72
	Цасгүй	6	33	77	0	32	11	12	46	25	17	28

Тайлбар: Цасан бүрхүүл (цастай, цасгүй)-ийн талбайн эзлэх хувийг МОДИС мэдрэгчийн Акуа/Терра хиймэл дагуулын 500 метрийн мэдээгээр тооцсон болно.


¹⁰ НҮБХХ-ийн “2009-2010 онд Монгол оронд тохиолдсон зудын сургамж” тайлан.2010 он.

бүтээгдэхүүн боловсруулдаг болон худалдаалдаг бизнес эрхэлдэг олон хүмүүст нөлөөлдөг.

Хүснэгт 1. Аймгуудын цасан бүрхүүлийн нөхцөл байдал

Цаг уур, орчны шинжилгээний газраас 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар зудын нөхцөл байдалд үнэлгээ хийхэд улсын хэмжээнд 13 аймгийн 58 суманд “төмөр зуд”-ын, 17 аймгийн 139 суманд “цагаан зуд”-ын, 18 аймгийн 69 суманд “цагаанаар зудархуу” нөхцөл байдалтай байгаа бөгөөд нийт 21 аймгийн 266 сум, нийслэлийн 2 дүүрэгт өвөлжилт хүндэрсэн байдалтай байна. Нийт нутгийн 80,6% зудын нөхцөл байгаагаас 21,8% төмөр зудтай, 52,3% цагаан зудтай, 25,9% цагаан зудархуу байна.¹¹

Зураг 1. ЗГ-ын 286 дугаар тогтоолын дагуу цаг агаарын нөхцөлд



суурилан үнэлсэн үнэлгээ.

¹¹ Улсын Онцгой комиссын Шуурхай штабын мэдээлэл

Нийт нутгийн 40 орчим хувьд олон жилийн дунджаас 1.1-8.1 градусаар хүйтэн, хур тунадас 60 гаруй хувьд олон жилийн дунджийн орчим буюу түүнээс ахиу байна.

Улсын Онцгой комисс өвөлжилт хүндэрсэн аймгуудын малын хорогдол, хүндэрч болзошгүй малчин өрхийн эрсдэлийн магадлал судалгааг дараах байдлаар гаргасан байна.

Мөн өвөлжилт хүндэрсэн 12 аймгийн Онцгой комиссоос 86 суманд 2024 оны 2-р сарын 19-нөөс 24-ний өдрийн хооронд 3716 малчин өрхөд 318,4 тонн өвс, 3659 малчин өрхөд 311,6 тонн тэжээл тарааж, 7249 км хаагдсан замыг давхацсан тоогоор 825 алба хаагч, 211 техник ажиллан зохион байгуулжээ.

Архангай аймгийн зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээ

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ

21 аймгийн хэмжээнд өвөлжих малын тоо: 64,238,714 мал - Хорогдсон малын тоо, хувь: 2024.02.15 611,443 толгой мал нийт мал сүргийн 1.0%, 2024.02.20 1,527,695 толгой мал нийт мал сүргийн 2.4%	21 аймгийн хэмжээнд малчин өрхийн тоо: 185,937 (мал бүхий өрх багтаагүй) - Нөхцөл байдал хүндэрсэн малчин өрхийн тоо, хувь: 2024.02.15 29,913 малчин өрх буюу нийт малчин өрхийн 16.0%, 2024.02.20 72,462 малчин өрх буюу нийт малчин өрхийн 37.5%
МАГАДЛАЛ Хорогдож болзошгүй малын тоо, хувь: 2024.02.27 нийт мал сүргийн 3.8% 2024.03.05 нийт мал сүргийн 5.2%	МАГАДЛАЛ Хүндэрч болзошгүй малчин өрхийн тоо, хувь: 2024.02.27 нийт малчин өрхийн 47.8% 2024.03.05 нийт малчин өрхийн 53.7%

хийх заавар батлах тухай” 68 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, “Ган, зудын эрсдэлийн үнэлгээ хийх тухай” 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн Архангай аймгийн 19 сумыг хамруулан зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийсэн.

Энэхүү үнэлгээний зорилго нь зудын эрсдэл өндөртэй сумдад зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шаардлагатай дэмжлэг, тусламжийг хүргэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран, уялдаа холбоог хангаж ажиллахад оршино.

Зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээнд ашигласан аргачлал: Зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийхдээ

- Таамаглал, магадлалын арга
- Олон жилийн судалгааны харьцуулалтын арга
- Ажиглалт, дүгнэлтийн арга
- Судалгаа, анализын аргуудыг ашиглав.

Зудын эрсдэлийг тодорхойлох үзүүлэлтүүдийг индексжүүлэх аргаар үнэлэн дараах байдлаар тодорхойлохоор тусгажээ.

$$R_{\text{зуд}} = \frac{H^*(E+V)}{C}$$

Тайлбар: H-аюул, E -өртөнги, V-эмзэг байдал, C- чадавх

“Ган, зудын гамшгийн эрсдэлийн үнэлгээний арга зүй” болон “Зудын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-д эрсдэлийг тодорхойлох үзүүлэлтүүдийг индексжүүлэх аргаар үнэлэн дараах байдлаар тодорхойлохоор тусгажээ.

Зудын аюул* (Бэлчээрийн өртөнги+Малын өртөнги)

Зудын эрсдэл= -----

Малчин өрхийн чадавх

Эмзэг байдлын шалгуур үзүүлэлтүүд

1. Аюулын шалгуур үзүүлэлтүүд

Зудын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээнд байгалийн хангай, тал хээрийн болон говийн бүсийн бэлчээрт орсон цасны зузаан ба цасны нягтралыг гол шалгуур үзүүлэлтүүд болгож авна. Эхний анхдагч аюулын үзүүлэлт бол өвлийн улиралд орсон цасны жилийн дунджийн хазайлтыг авна. Тухайн аймаг, сумын жилийн дундаж хур тунадас цасны үзүүлэлт тогтмол байхаар төсөөлнө. Хоёрдох гол үзүүлэлт нь тухайн аймаг сум орон нутагт орсон цасны дундаж нягтрал байна. Удаах үзүүлэлт нь зудын үеийн өвөлжилт хаваржилтын үргэлжлэх хугацааг харуулна. Нэг ба хоёрдугаар сар жилийн улирлын хамгийн их хүйтэрдэг сарууд нь байх бөгөөд эдгээр саруудад мал сүрэг ихээр хорогддог улирал юм.

2. Өртөнгийн шалгуур үзүүлэлтүүд

Өртөнгийн шалгуур үзүүлэлтэд зудын гамшигт өртөх малчин өрх ба мал сүргийн тоо, толгой, хорогдлыг авч үздэг. Эхний анхдагч шалгуурт зудын гамшгийн үед хамрагдсан бэлчээрийн газар нутаг байна. Онцгой байдлын ерөнхий газар болон ХХААХҮЯ –ны хорогдлын тайлан мэдээгээр тогтоохдоо аймаг, сум тус бүрийн нийт бэлчээрийн талбайд ноогдох цасан бүрхүүл тогтсон бэлчээрийг тооцно. Хоёр дахь өртөнгийн үзүүлэлтэд зудад нэрвэгдсэн малчин өрхийн тоог авч үздэг. Үндсэн суурь өгөгдөлд тухайн аймаг орон нутгийн нийт малчин өрхийн хэдэн нь зудын гамшигт нэрвэгдсэн байна гэдгийг авч үзнэ. Өртөнгийн гуравдахь үзүүлэлтэд зудын улмаас малчин өрхөд учирсан хохирлыг авч үзнэ. Одоогийн байдлаар зудын хохирлын талаар мэдээлэл байхгүй байгаа тул орон нутагт очиж малчин өрхөөс мэдээлэл авна.

Дөрөвдөх үзүүлэлт нь зудын давтамж байна. 10 жилийн хугацаанд 2 удаа тохиолдсон байдлыг гэж үзэж болно. Одоогийн байдлаар сүүлийн 10 жилд хоёр удаа хохирол ихтэй зуд тохиолдсон байна.

3. Дасан зохицох чадавхын үзүүлэлт

Үүнд малчдын эрт зарлан мэдээлэл хүлээн авах боломж болон мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангасан байдал, тухайлбал малаа тэжээлд оруулах аюулгүй өвс тэжээл, дулаан хашаа хороо, ус худаг гэх мэт зүйлүүдийг шалгуур үзүүлэлтэд авч үзнэ. Нэгдэх шалгуур үзүүлэлт нь малчин өрхийн малын индексжүүлэлтийн даатгалд хамрагдсан байдал, хоёрдугаарт олон нийтийн телевиз, радио, гар утас, интернет гэх мэт бусад арга хэрэгслээр зарлан мэдээллийн авсан байдал. Гуравдугаарт аюулгүй өвс тэжээлийн нөөц болон дулаан хашаа хороо, худаг усны хүрэлцээ шалгуур үзүүлэлтээр авна. Түүнчлэн 2020-2021 оны сургамжинд үндэслэн малын тарга хүч, эрүүл мэнд малын үржил, тээвэр зохицуулалт, нийгмийн үйлчилгээний боломж, малчдын туршлага, ур чадвар, сургалт зэрэг үзүүлэлтүүдийг нэмж оруулав. Хүснэгт 4.1 ба 4.2 -хүснэгтэд зудын эмзэг байдлын үнэлгээний үзүүлэлтийг харуулав.¹²

Хүснэгт 2. Аюулын үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Ангиллын хуваарь	Уулын бүс	Хээрийн бүс	Говийн бүс	Үнэлгээ
Цасан бүрхүүл /30 жилийн дундаж/	Бэлчээрийн цасны зузаан:уулын болон ойн бүсэд 21 см, тал хээрийн бүсэд 16 см, говийн бүсэд 10 см-ээс их	≥21 см	≥ 16 см	≥10 см	1.0 маш өндөр
		21 см	21 см	10 см	0.8 өндөр
		16 см	16 см	5 см	0.6 дунд
		10 см	10 см	3 см	0.4 бага
		≤10 см	≤5 см	≤3 см	0.2 маш бага
Цасны нягт /30 жилийн дундаж/	Бүх бүс нутагт цасны нягт 0.20 гр/см ³	≥ 0.20 гр/см ³ бүх бүс			1.0 маш өндөр
		0.20 гр/см ³			0.8 өндөр
		0.15 гр/см ³			0.6 дунд
		0.10 гр/см ³			0.4 бага
		≤0.10 гр/см ³			0.2 маш бага
Агаарын дундаж температур	Агаарын температур - 20 ⁰ С -аас бага мөн удаан хугацаагаар үргэлжлэх	≥ - 30 ⁰ С			1.0 маш өндөр
		-20 ⁰ -30 ⁰ С			0.8 өндөр
		-15 ⁰ -20 ⁰ С			0.6 дунд
		-10 ⁰ -20 ⁰ С			0.4 бага
		≤- 10 ⁰ С			0.2 маш бага
Давта мж	Уулын болон ойн бүсэд 3, тал хээрийн	≥ 3			1.0 маш өндөр
		3			0.8 өндөр
		2			0.6 дунд

¹² Ш.Болдбаатар, Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх зудын гамшигийн эрсдэлийг бууруулах арга зам, УБ хот, 2016.х-88.

	бүсэд 2, говийн бүсэд 1-ээс их	1	0.4 бага
		≤ 1	0.2 маш бага
Бэлчээрийн даац /сүүлийн 5-	Бэлчээрийн нөөцөөс хамаарсан даац хэтрэлт, хувиар	$\geq 100 \%$	1.0 маш өндөр
		51-100 %	0.8 өндөр
		31-50 %	0.6 дунд
		21-30 %	0.4 бага
		$\leq 20 \%$	0.2 маш бага
		≥ 41	1.0 маш өндөр
Ургамалжи лт	Ургамалын аривын жишиг, бодгаль хоорондын зай, см	31-40	0.8 өндөр
		21-30	0.6 дунд
		11-20	0.4 бага
		≤ 10 см	0.2 маш бага
Ган	Гангийн эрчимшил	Маш хүчтэй	1.0 маш өндөр
		Хүчтэй	0.8 өндөр
		Гантай	0.6 дунд
		Гандуу	0.4 бага
		Гангүй	0.2 маш бага

Хүснэгт 3. Эмзэг байдлын үзүүлэлтүүд

Үзүүлэлтүү д	Ангилалын хуваарь	Уулын бүс	Хээрийн бүс	Говийн бүс	Үнэлгээ
Өртөлтийн үзүүлэлтүүд:					
Бэлчээр	Зудад өртөх талбай, нийт бэлчээрт эзлэх хувь	$\geq 50 \%$			1.0 маш өндөр
		41-50 %			0.8 өндөр
		31-40 %			0.6 дунд
		21-30 %			0.4 бага
		$\leq 20 \%$			0.2 маш бага
Хүн амын тоо	МАА-аас хамааралтай хүн ам	$\geq 50 \%$			1.0 маш өндөр
		41-50 %			0.8 өндөр
		31-40 %			0.6 дунд
		21-30 %			0.4 бага
		$\leq 20 \%$			0.2 маш бага
Эмзэг бүлгийн хүн амын тоо	Хүн амын МАА- аас хамааралтай эмзэг бүлгийн эзлэх хувь	$\geq 50 \%$			1.0 маш өндөр
		41-50 %			0.8 өндөр
		31-40 %			0.6 дунд
		21-30 %			0.4 бага
		$\leq 20 \%$			0.2 маш бага
Хорогдсон малын тоо толгой	нийт малаас эзлэх хувь, %	$\geq 50 \%$			1.0 маш өндөр
		41-50 %			0.8 өндөр
		31-40 %			0.6 дунд
		21-30 %			0.4 бага
		$\leq 20 \%$			0.2 маш бага
Э д и й		$\geq 50 \%$			1.0 маш өндөр

	ДНБ-д ХАА-н салбарын эзлэх хувь	41-50 %	0.8 өндөр
		31-40 %	0.6 дунд
		21-30 %	0.4 бага
		≤ 20 %	0.2 маш бага
Дасан зохицох чадавхын үзүүлэлтүүд			
Даатгалд хамрагдалт	Индексжүүлсан малын даатгалд хамрагдсан малчин өрхийн эзлэх хувь	81-100%	0.2 маш өндөр
		61-80%	0.4 өндөр
		41-60%	0.6 дунд
		21-40%	0.8 бага
		<20%	1.0 маш бага
Зарлан мэдээлэл авах боломж	Зудын урьдчилсан мэдээллийн хангалт	Зарлан мэдээлэл дамжуулах боломжтой	0.2 маш өндөр
		Зарим бус нутгийг тодорхойлж зарлан мэдээлэл дамжуулах боломжтой	0.4 өндөр
		Зудын эрсдэлтэй бүс нутгийг тодорхойлсон ч зарлан мэдээллийг бүрэн дамжуулж чаддаггүй	0.6 дунд
		Зарлан мэдээлэл систем байдаг ч ажилладаггүй	0.8 бага
		Зарлан мэдээллийн систем байдаггүй отор нүүдэл хийх боломжгүй	1.0 маш бага
Зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөлт, бэлэн байдал	Уст цэгийн хүрэлцээ, дулаан хашаа, өвөлжөө, яаралтай тусламжийн малын өвс, тэжээлийн сангийн бэлтгэл	Өвөлжилтийн бэлтгэл ажил : Аймгийн хэмжээнд бэлтгэлээ бүрэн хангасан, уст цэг, дулаан хашаа, өвөлжөө, яаралтай тусламжийн малын өвс, тэжээлийн сан хүрэлцээтэй 80% хангасан 50%-аас дээш хангасан <50%-аас доош хангасан Өвөлжилтийн бэлтгэл хангаагүй, өвөлжөө, уст цэг хангалтгүй	0.2 маш өндөр 0.4 өндөр 0.6 дунд 0.8 бага 1.0 маш бага
		81-100%	0.2 маш өндөр
		61-80%	0.4 өндөр
		41-60%	0.6 дунд
		21-40%	0.8 бага
Малын тарга хүч, эрүүл мэнд	Эрүүл, тарга хүч сайтай малын эзлэх хувь	<20%	1.0 маш бага
		81-100%	0.2 маш өндөр
		61-80%	0.4 өндөр
		41-60%	0.6 дунд
		21-40%	0.8 бага
Малын үржил	Хээлтүүлэгч, хээлтэгчийн чанар байдал, баталгаажуулалт	<20%	1.0 маш бага
		81-100%	0.2 маш өндөр
		61-80%	0.4 өндөр
		41-60%	0.6 дунд
		21-40%	0.8 бага

Тээвэр зохицуулалт	Аймгийн отор нүүдлийн болон өвс тэжээлийн авто тээврийн ложистикийн зохион байгуулалт, зохицуулалтын түвшин	5 маш сайн	0.2 маш өндөр
		4 сайн	0.4 өндөр
		3 дунд	0.6 дунд
		2 сул	0.8 бага
		1 маш сул	1.0 маш бага
Нийгмийн үйлчилгээний боломж	Хүн, мал эмнэлгийн болон бусад нийгмийн үйлчилгээний түвшин	5 маш сайн	0.2 маш өндөр
		4 сайн	0.4 өндөр
		3 дунд	0.6 дунд
		2 сул	0.8 бага
		1 маш сул	1.0 маш бага
Малчдын туршлага, ур чадвар, сургалт	Нийт малчин өрхөд эзлэх хувь	81-100%	0.2 маш өндөр
		61-80%	0.4 өндөр
		41-60%	0.6 дунд
		21-40%	0.8 бага
		<20%	1.0 маш бага

Жинлүүрийн хуваарилалт. Сүүлийн жилүүдэд хийсэн судалгаа, шинжилгээнд тулгуурлан аюул, эмзэг байдлын шалгуур болон дэд шалгуур үзүүлэлтээр зудын үр нөлөөллийн дарах жинг тодорхойлно. Хуваарилагдсан нийт жинлүүрийн хувь аюул, өртөнги, дасан зохицох чадавх зэрэг үзүүлэлт болон үзүүлэлт тус бүрийн дэд шалгуур үзүүлэлт нь 100%-иас хэтрэх ёсгүй. Хүснэгт 4.3-т шалгуур үзүүлэлт болон дэд шалгуур үзүүлэлт тус бүрийн жинлүүрийн хуваарилалтыг үзүүлэв.

Хүснэгт 4. Жинлүүрийн хуваарилалт

Эрсдэлийн үзүүлэлт	Жин	Эрсдэлийн үзүүлэлт	Жин	Эрсдэлийн үзүүлэлт	Жин	Нийт
Аюул	40%	Өртөнгө	25%	Дасан зохицох чадавх	35%	100%
Аюулын үзүүлэлт	Жин	Өртөнгийн үзүүлэлт		Дасан зохицох чадавхын үзүүлэлт		
Цасны зузаан	15%	Бэлчээр	30%	Удирдлагын тогтолцоо	15%	
Цасны нягт	15%	Хүн амын тоо	20%	Зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөлт, бэлэн байдал	15 %	
Агаарын температур	15%	Малын тоо толгой	30%	Мэдээллийн хэрэгслээр хангагдсан болон	10%	
Давтамж	5%	Эдийн засаг	20%	Даатгалд хамрагдалт	15%	
Бэлчээрийн даац	15%			Малын тарга хүч, эрүүл мэнд	15%	
				Малын үржил	15%	

Ургамалжилт	10%			Нийгмийн үйлчилгээний боломж	5%	
Ган	25%			Малчдын туршлага, ур чадвар, сургалт	10%	
	100%		100%		100%	

Зудын эмзэг байдлын үнэлгээг 19 сумдад хийхэд дараах үр дүн гарав.

Зудын эрсдэлийн өнөөгийн нөхцөл байдал:

Архангай аймгийн хэмжээнд 19 сумын 101 багийн 8,2 мянган хот айлд 19,7 мянган малчин, мал бүхий өрхөд 4,8 сая толгой малыг өвөлжиж, хаваржих төлөвтэй байна.

Отор нүүдлийн талаар: 2023 онд 4.8 сая толгой мал өвөлжүүлж, хаваржуулах ба үүнээс улсын тусгай хамгаалалттай бүс нутагт Хангай, Чулуут, Булган, Цэнхэр, Тариат, Цахир, Ихтамир сумдын 454 өрхийн 154.9 мянган толгой мал өвөлжиж, хаваржина.

Гадны аймгаас: Завхан, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай, Сүхбаатар аймгаас 23 өрхийн 3,1 мянган толгой мал Ихтамир, Цэнхэр, Булган, Чулуут, Жаргалант, Өгийнуур сумын нутагт отроор өвөлжиж байна.

Гадны аймагт: Хашаат, Хотонт, Хангай, Цахир, Цэнхэр, Цэцэрлэг, Эрдэнэмандал, Жаргалант, Хайрхан сумдын 82 өрхийн 36,4 мянган толгой мал Булган, Хөвсгөл, Төв, Завхан, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ аймагт отроор

Аймаг дотроо: Жаргалант, Тариат, Чулуут, Цахир, Хангай, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Хотонт, Хайрхан сумдын 268 өрхийн 124.0 мянган толгой мал Өндөр-Улаан, Ихтамир, Цэцэрлэг, Эрдэнэмандал, Тариат, Чулуут, Батцэнгэл, Булган, Хотонт, Хангай, Өгийнуур, Хашаат, Өлзийт суманд тус тус отроор өвөлжиж байна.

Малын зүй бус хорогдол: Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн мал тооллогоор урьдчилсан дүнгээр 4,8 сая толгой мал тоологдсон.

2023 онд нийт мал сүргийн 9.7 хувь нь хорогдсон. Үүнээс тэмээ- 52 толгой, адуу- 50215 толгой, үхэр- 78927 толгой буюу, хонь-267894 толгой буюу, ямаа- 176140 толгой хорогдсон. Нийт **573228** толгой мал хорогдсон байна.

2023 оны 12 сарын 1-с 2024 оны 1 сарын 5 хооронд нийт 14821 толгой мал хорогдоод байна. Үүнээс адуу- 568 толгой, үхэр- 4939 толгой, хонь- 5575 толгой, ямаа- 3739 толгой хорогдсон мэдээтэй байна.

Зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээний үр дүн

Зудын аюулын үнэлгээ


Үзүүлэлт	Түвшин /нутаг дэвсгэрээр/	Үнэлгээ	Үнэлгээ	Дундаж	Тайлбар
----------	------------------------------	---------	---------	--------	---------

			/ба лл/			
Агаарын температур, цельс	ОЖД-аас 3.0°C түүнээс илүү хүйтэн	Нийт нутаг дэвсгэрийн 90%-аас дээш	10	10	10	Агаарын дундаж температурыг олон жилийн дундажтай харьцуулахад 2023 оны 12-р сарын 1-р арав хоногт нийт нутгаар 2,4-5,7 градус хүйтэн, 2 дугаар арав хоногт 5,8-10,9 градус хүйтэн, 3-р арав хоногт Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Батцэнгэл, Булган, Жаргалант, ӨндөрУлаан, Хангай, Хайрхан, Хашаат, Хотонт, Цэцэрлэг, Чулуут, Цэнхэр, Ихтамир сумдын нутгаар 1,2-5,1 градус хүйтэн, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байлаа. Энэ сарын 31-ний байдлаар аймгийн нийт нутгаар өдөр шөнийн температурын хэлбэлзлэл ихтэй, агаарын дундаж температур олон жилийн дунджаас нийт нутгаар хүйтэн, агаарт шөнөдөө 30,0 -43,0 градус, хөрсөнд шөнөдөө 36,0 – 44,0 градус хүрч хүйтэрч, цасан шуурга ихтэй байгаа нь зам даваа хаагдах, малын бэлчээрлэлт, мал өвөлжилтийн байдлыг хүндрүүж байна.
		Нийт нутаг дэвсгэрийн 60-90%	9			
		Нийт нутаг дэвсгэрийн 30-60%	8			
		Нийт нутаг дэвсгэрийн 30% хүртэлх	7			
	ОЖД-аас 2.0-2.9°C хүйтэн	Нийт нутаг дэвсгэрийн 60-100%	6			
		Нийт нутаг дэвсгэрийн 30-60%	5			
		Нийт нутаг дэвсгэрийн 30% хүртэлх	4			
	ОЖД орчим ба ОЖД –аас 1.9°C хүртэлх хүйтэн	Нийт нутаг дэвсгэрийн 60-100%	3			
		Нийт нутаг дэвсгэрийн 30-60%	2			
		Нийт нутаг дэвсгэрийн 30% хүртэлх	1			
Гангай		Нийт нутаг дэвсгэрийн 90%-аас дээш	10	8	7	Манай аймгийн хэмжээнд 2023 оны 5 дугаар сарын 31-ны байдлаар бэлчээрийн ургамлын ургалт Цэцэрлэг, Хашаат, Чулуут, Хангай, Цахир сумдын нутгаар гандуу, бусад нутгаар гангай байсан. 6-р сарын 30-ны байдлаар Хашаат, Чулуут, Хангай, Цахир сумдаар гандуу байсан
		Нийт нутаг дэвсгэрийн 60-90%	9			
		Нийт нутаг дэвсгэрийн 30-60%	8			
		Нийт нутаг дэвсгэрийн 30% хүртэлх	7			

Гандуу	Нийт нутаг дэвсгэрийн 90%-аас дээш	6	6	тул гангийн үнэлгээг 5,6 сар, 7 сарын 10-ны байдлын мэдээгээр гангийн үнэлгээг үнэлэв. Архангай аймгийн Бэлчээрийн ургамлын ургамлын байдал 2023 оны 05 дугаар сарын 20-ны байдлаар Архангай аймгийн Бэлчээрийн ургамлын ургамлын байдал 2023 оны 5 дугаар сарын 21-ны байдлаар Архангай аймгийн Бэлчээрийн ургамлын ургамлын байдал (2023 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар)
	Нийт нутаг дэвсгэрийн 60-90%	5		
	Нийт нутаг дэвсгэрийн 30-60%	4		
	Нийт нутаг дэвсгэрийн 20-30%	3		
	Нийт нутаг дэвсгэрийн 10-20%	2		
	Нийт нутаг дэвсгэрийн 10% хүртэлх	1		Зуншлагын байдал 2023 оны 7 дугаар сарын дунд арав хоногоос эхлэн аймгийн нийт нутгийн 90 хувьд нь хэвийн, 10 орчим хувьд нь дунд байсан ч 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгаар зуншлагын байдал сайн байлаа. Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл нийт нутгийн: 8.3 % - Бэлчээрийн нөөцтэй 23.5 % - Бэлчээр хүрэлцээтэй 60.2% - Даац 1-3 дахин хэтэрсэн 7.2 % - Даац 3-5 дахин хэтэрсэн 0.8% - Даац олон дахин хэтэрсэн байна.

Цасны зузаан /см/	Ойт хээр, хээрийн бүсэд	16-25 см-ээс их	Нийт нутаг дэвсгэрийн 90%-аас дээш	10	9	6	2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Архангай аймгийн нийт нутгаар цасан бүрхүүл тогтсон, аймгийн нийт зудын эрсдэлтэй. 12 дугаар сарын 20-ны байдлаар сумын төвийн ойролцоо хэмжсэн цасны мэдээгээр цасны дундаж зузаан Тариат, Төвшрүүлэх, Хайрхан сумдын нутгаар 16 - 20 см, Эрдэнэбулган, бусад сумдын нутгаар 1 - 15 см цастай байна. Цаг хүндэрсэн үеийн (багт хийсэн цасны мэдээ) цасны нэмэлт ажиглалтын мэдээгээр Эрдэнэмандал, Жаргалант, Цахир, Төвшрүүлэх, Хайрхан, Өгийнуур, Өлзийт, Чулуут, Хангай Тариат, сумдын	
							Нийт нутаг дэвсгэрийн 30-60%	8
							Нийт нутаг дэвсгэрийн 30%-хүртэлх	7
							Нийт нутаг дэвсгэрийн 60-100%	6
							Нийт нутаг дэвсгэрийн 30-60%	5
		11-22 см	6	6	нутгаар цасны дундаж зузаан 16 -33 см, дундаж нягт 0,16 - 0,37 г/см ³ байсан байна. 12-р сарын 31 -ны байдлаар сумын төвийн ойролцоо хэмжсэн цасны мэдээгээр цасны дундаж зузаан Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Батцэнгэл, Хайрхан сумдын нутгаар 15-21 см, Цахир, Тариат, Хангай, Өгийнуур, Жаргалант сумдын нутгаар 12-14см, бусад сумдын нутгаар 5-10 см байлаа. Цаг хүндэрсэн үеийн цасны нэмэлт ажиглалтын мэдээгээр			

			Нийт нутаг дэвсгэрийн 30% хүртэлх	4		(багт хийсэн цасны мэдээ) Эрдэнэмандал сумын нутгаар цасны дундаж зузаан 20 -37 см, дундаж нягт 0,20 -0,29 г/см ³ , Цэцэрлэг сумын нутгаар цасны дундаж зузаан 12 -20 см, дундаж нягт 0,20 - 0,26 г/см ³ байлаа.
	5-12 см	Нийт нутаг дэвсгэрийн 60-100%		3	3	
		Нийт нутаг дэвсгэрийн 30-60%		2		
		Нийт нутаг дэвсгэрийн 30% хүртэлх		1		
Цасны нягт г/см ³	0.20-ооших	Нийт нутаг дэвсгэрийн 90%-аас дээш		10	10	8 12 дугаар сарын 20-ны байдлаар сумын төвийн ойролцоо хэмжсэн цасны мэдээгээр цасны дундаж нягт нь Тариат, Цахир, Эрдэнэмандал, Өндөр Улаан, Хайрхан, Жаргалант сумдын нутгаар 0,21 -0,28 г/см ³ , бусад сумдын нутгаар 0,06 -0,20 г/см ³ , цаг хүндэрсэн үеийн цасны нэмэлт ажиглалтын мэдээгээр (багт хийсэн цасны мэдээ) Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Хайрхан, Цахир, Жаргалант, Өгийнуур, Өлзийт, Чулуут сумын нутгаар цасны дундаж нягт 0,16 -0,37 г/см ³ байсан байна.12-р сарын 31 -ны байдлаар сумын төвийн ойролцоо хэмжсэн цасны мэдээгээр цасны дундаж нягт
		Нийт нутаг дэвсгэрийн 60-90%		9		
		Нийт нутаг дэвсгэрийн 30-60%		8		
		Нийт нутаг дэвсгэрийн 30% хүртэлх		7		
	0.10-0.20	Нийт нутаг дэвсгэрийн 60-100%		6	6	
		Нийт нутаг дэвсгэрийн 30-60%		5		
		Нийт нутаг дэвсгэрийн 30% хүртэлх		4		

0.10 хүртэ лх	Нийт нутаг дэвсгэрийн 60-100%	3	-	Эрдэнэбулган, Цэцэрлэг сумдын нутгаар 0,09-0,15 г/см³, Тариат, Цахир, Эрдэнэмандал сумдын нутгаар 0,23-0,29 г/см³, бусад сумдын нутгаар 0,16-0,22 г/см³ байлаа. Архангай аймгийн цасны дундаж нягт, г/см³ (2023 оны 12-р сарын 31-ний байдлаар) 
	Нийт нутаг дэвсгэрийн 30-60%	2		
	Нийт нутаг дэвсгэрийн 30% хүртэлх	1		
Цасны бүрхэлц	Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 100%	10	10	Цаг хүндэрсэн үеийн цасны нэмэлт ажиглалтын мэдээгээр (багт хийсэн цасны) Эрдэнэмандал сумын нутгаар цасны дундаж нягт 0,20 -0,29 г/см³, Цэцэрлэг сумын нутгаар цасны дундаж нягт 0,20 -0,26 г/см³ байсан байна. Архангай аймгийн хэмжээнд бүх нутгаар цасан бүрхүүл тогтсон. мал өвөлжилтийн байдал хүндэрсэн байна. 2023 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар гарсан зудын эрсдлийн зургаар аймгийн нийт нутгийн 7,1 хувь нь эрсдэлтэй, 43,2 хувь нь их эрсдэлтэй, 49,6 хувь нь нэн их эрсдэлтэй байна. АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРСДЛИЙН ЗУРАГ (2023 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар) 
	Нийт нутаг дэвсгэрийн 90%	9		
	Нийт нутаг дэвсгэрийн 80%	8		
	Нийт нутаг дэвсгэрийн 70%	7		
	Нийт нутаг дэвсгэрийн 60%	6		
	Нийт нутаг дэвсгэрийн 50%	5		
	Нийт нутаг дэвсгэрийн 40%	4		
	Нийт нутаг дэвсгэрийн 30%	3		
	Нийт нутаг дэвсгэрийн 20%	2		
	Нийт нутаг дэвсгэрийн 10% хүртэлх	1		
	Цасгүй	10		
Бүх онооны нийлбэр			41/5	
Дундаж оноо			8.2	

Өртөнгө, эмзэг байдлын үнэлгээ

Үзүүлэлт	Түвшин	Онооны тоон утга	Үнэлгээ	Тайлбар
----------	--------	------------------	---------	---------

Малын тарга хүч авсан байдал	Дундаас дээш		1-3	7	Энэ жилийн хувьд бороо хур их зуншлага сайн байсан учир мал тарга тэвээргэ сайн авсан. 19 сумын дундажаар нийт малын 88,2 хувь нь дундаас дээш тарга тэвээргэ авсан байна.
	Дунд		4-6		
	Дундаас доош		7-10		
Бэлчээрийн даац	50% хүртэлх	Бэлчээрийн нөөцтэй	1-3	7	Бэлчээрийн даацыг аймгийн нийт нутгаар тооцоолж гаргасан дүнгээс (Бэлчээрийн даацын зураг, 2023 оны 08 дугаар сарын 23-нд УЦУОСМХ-д боловсруулав) үзвэл нутгийн 8.3 хувь нь бэлчээр нөөцтэй, 23.5 хувь нь бэлчээр хүрэлцээтэй, 60.2 хувь нь 1-3 дахин хэтэрсэн, 7.2 хувьд даац 3-5 дахин хэтэрсэн, 0.8 гаруй хувьд нь олон дахин хэтэрсэн байдалтай байна. Өөрөөр хэлбэл өвөл-хаврын бэлчээрийн даац нутгийн 30 гаруй хувьд хүрэлцээтэй, харин 70 орчим хувьд нь хэтэрч гарлаа.
	51-100	Бэлчээр хүрэлцээтэй	4-6		
	100%-аас их	Даац хэтэрсэн	7-10		
<u>Ургамлын ариу</u>	Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд	Маш элбэг, ургамал хоорондын зай 20см-ээс бага	1-2	5	Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд элбэг ургамал хоорондын зай 25 см-ээс бага байна.
	Нийт нутаг дэвсгэрийн 40-80%	Элбэг, ургамал хоорондын зай 21-40 см-ээс бага	3-6		
	Нийт нутаг дэвсгэрийн 40% хүртэлх	Бага, ургамал хоорондын зай 41 см-ээс их	7-10		
Малчдын түвшинд бэлтгэх	90%<		1-3	3	Малчдын түвшинд 80 мянган тн өвс, 1300 тн гар тэжээл бэлтгэхээс өнөөдрийн байдлаар 73,9 мянган тн өвс, 2,07 мянган тн ногоон тэжээл, 25 тн үйлдвэрийн тэжээл, 1295 тн гар тэжээл, 2723 тн хужир
	40-90 %		4-6		
	≤40%		7-10		

					шүү бэлтгэн хадлан бэлтгэл 98,8 хувьтай байна.
Аюулгүйн нөөц /Засгийн газрын 186-р тогтоол /	Өвс	90%<	1-3	5	Аймгийн нөөцөд 100 тн өвс, 50 тн тэжээл бэлтгэхээс өвс 100 тн, тэжээл 50 тн бэлтгэж 100 хувь, сумын аюулгүйн нөөцөд 950 тн өвс, 570 тн гар тэжээл бэлтгэхээс сумдын аюулгүйн нөөцөд 796,3 тн өвс, 383 тн тэжээл, 25 тн хужир шүү бэлтгэн сумдын аюулгүй нөөц 77 орчим хувьтай байна.
		50-90 %	4-6		
		≤50%	7-10		
	Тэжээл	90%<	1-3		
		50-90 %	4-6		
		≤50%	7-10		
Малчин өрхийн эмзэг бүлгийн иргэд /хөгжлийн бэрхшээлтэй, өндөр	30% >		1-3	5	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Статистикийн хэлтсээс гаргасан судалгаагаар Архангай аймгийн нийт хүн ам 2023 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр 95253 болж, үүнээс 0-4 насны хүүхэд 9924, өндөр настан 10420 байна. Хөгжлийн бэрхшээлтэй 3652 иргэд байгаа нь нийт хүн амын 3.8 % -ийг тус тус эзэлсэн байна.
	30-70%		4-6		
	70%<		7-10		
Малчдын амьжиргааны түвшин /хонин толгойд шилжүүлсэнээр /	800-аас дээш малтай	70% <	1	3	4,6
		30-70%	2		
		30%>	3		
	200-800 малтай	70% <	4	5	36,9
		30-70%	5		
		30%>	6		
	200 хүртэлх малтай	30% >	7	8	58,4
		30-70%	8		
		70%<	9-10		
Өр зээлтэй малчин өрх	≤30%		1-3	5	Банкинд зээлтэй малчин өрх нийт малчин өрхийн 48 орчим хувь байна.
	30-70 %		4-6		
	70%<		7-10		
Төв суурин газраас алслагдсан айл өрх	20 хүртэлх хувь	<30 км	1	5	Аймгийн хэмжээнд 20-аас дээш хувь нь төв суурин газраас багадаа 50 км алслагдсан айл өрхүүд байна.
		30-50 км	2		
		50 км <	3		
	20-60 хувь	≤ 30 км	4		
		30-50 км	5		
		50 км <	6		
	60 хувиас их	≤ 30 км	7		
		30-50 км	8		

		50 км <	9-10		
Эмнэлг ийн туслам ж, үйлчилг ээнээс алслагд сан малчин өрх	80%<	7-10	9		Аймаг дотроо 89 өрхийн 247 иргэн отроор явж байна. Сум дундын эмнэлэгийн тусламж авах бүрэн боломжтой байна.
	40-80 %	4-6			
	≤40%	1-3			
Үүрэн холбоо хэрэглэ дэг малчин өрх	Их	80 % <	1-3	3	Нийт малчин өрхийн 92,2 буюу 15,3 мянган малчин өрх үүрэн холбоо ашиглаж байна.
	Дунд	40-80%	4-6		
	Бага	≤40 %	7-10		
Малчин өрхийн хашаа хороон ы байдал	Сайн	80 %<	1-3	3	Аймгийн хэмжээнд 14,9 мянган ширхэг бодын хашаа, 18,7 мянган ширхэг богийн хашаа нийт 33,6 мянган ширхэг малын хашаа шаардлагатайгаас 32,2 мянган ширхэг малын хашаа буюу 95.8 хувийн хангамжтай байна. Энэ онд 201 ширхэг бодын хашаа, 337 ширхэг богийн хашааг шинээр барьж ашиглалтад оруулсан.
	Дунд	40-80%	4-6		
	Хангалтгүй	≤40 %	7-10		
Худаг усны хүртээм ж	Сайн	80 % <	1-3	3	Аймгийн хэмжээнд нийт 1070 бэлчээрийн худаг байна. Үүнээс инженерийн хийцтэй гүн өрмийн 959 худаг, энгийн уурхайн 113 худаг, 3 усан сан байгаа бөгөөд ашиглагдаж байгаа 959 худаг буюу нийт худгийн 88.2 хувийг ашиглаж, Нийт өрхийн буюу 98.4 хувь нь усаар хангагдсан байна.
	Дунд	40-80%	4-6		
	Хангалтгүй	≤ 40 %	7-10		
Дулаан ы түлшний хүрэлцэ э	3 сар	80 % <	1-3	10	Архангай аймгийн төвд болох Эрдэнэбулган суманд 1-2 сарын түлшний нөөц байгааг алсагдсан сумдад түлшний хүртээмж 1 сараас ч хүрэхгүй хэмжээнд байна.
	1-3 сар	40-80%	4-6		
	< 1 сар	≤ 40 %	7-10		
	Их	80 %<	7-10	10	

Зам, гүүрийн хаагдах байдал	Дунд	40-80%	4-6		Цасан шуурга их байгаа улмаас сумдын зам, гүүр даваа их хэмжээгээр хаагдаж байна. Зам, давааг нээсэн ч 2-3 өдрийн дараа шуурганд зам даваа буцан хаагдаж байна.
	Бага	≤40 %	1-3		
Нийт оноо				85.3/15	
Дундаж оноо				5.7	

Зудын эрсдэлийг бууруулах болон зудтай тэмцэх чадавхын үнэлгээ

Чадавхын үзүүлэлт	Түвшин	Онооны тоон утга	Үнэлгээ	Тайлбар	
Удирдлага, зохион байгуулалт (Аймгийн отор нүүдлийн болон өвс тэжээлийн авто тээврийн ложистикийн зохион байгуулалт, зохицуулалт)	Дундаас дээш	7-10	3	Сумдын багрүү өвс тэжээл болон отор нүүдэл хийхэд тээврийн зохицуулалт хангалтгүй сум болгонд тээвэр хийх том оврийн ачааны машин байхгүй бөгөөд Онцгой байдлын газар болон 342 дугаар цэргийн ангийн авто машинаар өвс тэжээлийн хүргэлтийг хийж байна.	
	Дунд	4-6			
	Дундаас доош	1-3			
Зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөлт, бэлэн байдал /Гамшгаас хамгаалах төлөвлөгөө/	Сайн	80 %<	7-10	2	Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ боловсруулан танилцуулдаг ч хангалттай хэмжээнд шийдэж бэлтгэл бэлэн байдлыг хангуулах нөхцөлийг бүрдүүлж өгдөггүй.
	Дунд	40-80%	4-6		
	Хангалтгүй	≤40 %	1-3		
Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахад олон нийтийн оролцооны түвшин	Сайн	80 %<	7-10	1	Аймгийн хэмжээний гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах зөвхөн мэргэжлийн байгууллагын алба хаагчид оролцдог бөгөөд олон нийтийг хамруулдаггүй.
	Дунд	40-80%	4-6		
	Хангалтгүй	≤40 %	1-3		
Олон нийтийн оролцоо	Сайн	80 %<	7-10	1	Иргэдийн оролцоо маш хангалтгүй байна. Зөвхөн
	Дунд	40-80%	4-6		

/малчдын бүлэг нөхөрлөлд хамрагдсан байдал/	Хангалтгүй	≤40 %	1-3		өөрийн эрх ашгийн төлөө малчдын нөхөрлөлд хамрагдаж байгаа сонгуулийн үеэр харагддаг зудын үед ямар ч хамтын ажиллагаа байхгүй.	
Санхүү	Аймгийн Засаг даргын нөөц	80 %<	7-10	1	3.7	Аймгийн Засаг даргын нөөц, сумдын Засаг даргын нөөц, гамшгаас хамгаалах зардал дээр хангалттай төсөв хөрөнгийг суулгадаг бөгөөд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр ямар ч ажил хийгддэггүй бөгөөд гамшгийн үед төсөв мөнгө их гаргаж байна. Засгийн газрын тогтоолоор гамшгийн эрсдэлийг бууруулах зардал гэж оруулж өгч гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ үр дүнтэй болно гэж үзэж байна.
		40-80%	4-6			
		≤40 %	1-3			
	Сумын Засаг даргын нөөц сан	80 %<	7-10	1		
		40-80%	4-6			
		≤40 %	1-3			
		40-80%	4-6			
		≤40 %	1-3			
	Гамшгаас хамгаалах сан	80 %<	7-10	3		
		40-80%	4-6			
		≤40 %	1-3			
	Төсвийн тодотгол, ЗГ-ын тогтоолоор нэмж бүрдүүлэх боломжтой эсэх	Боломжтой	10	10		
		Боломжгүй	1			
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж	Сайн	80 %<	7-10	8	Аймгийн хэмжээнд Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төв-3, Сумын эрүүл мэндийн төв-19, Сувилал-3, Хувийн ортой эмнэлэг-6, Эм ханган нийлүүлэх төв-4, Нийтийн үйлчилгээтэй эмийн сан-52 тус тус үйл ажиллагаа явуулж байна.	
	Дунд	40-80%	4-6			

	Хангалтгүй	≤40 %	1-3		Аймгийн хэмжээнд 208 их эмч, 297 сувилагч нийт 1255 эмнэлгийн тусгай дунд мэргэжилтэн ажиллаж байна.Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц-75 хувь, эмнэлгийн тоног төхөөрөмж нөөцийн хүрэлцээ-85 хувьтай байна.
Мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмж	Сайн	80 %<	7-10	6	Булган, Чулуут сумдын мал эмнэлгийн тасагт ажиллах хүний нөөц байхгүй. Мөн Жаргалант сумд тархвар зүйчийн 1 орон тоо, Хангай сумд тархвар зүйчийн 1 орон тоо, Хайрхан сумд тархвар зүйчийн 1 орон тоо, Жаргалант сумд тархвар зүйчийн 1 орон тоо, Өндөр-Улаан сумд улсын байцаагчийн орон тоо дутуу нийт 7 сумд 9 хүний нөөцийн орон тоо дутуу байна.
	Дунд	40-80%	4-6		
	Хангалтгүй	≤40 %	1-3		
Нийгмийн халамж үйлчилгээний хүртээмж	Сайн	80 %<	7-10	4	Халамжийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэн
	Дунд	40-80%	4-6		
	Хангалтгүй	≤40 %	1-3		
Нөөц, хүч хэрэгслийн боломж /төрийн өмчит байгууллагын хэмжээнд/	Сайн	80 %<	7-10	1	Сумдын хэмжээнд нөөц, хүч хэрэгслийн боломж төрийн байгууллагуудын дунд маш хангалтгүй байна
	Дунд	40-80%	4-6		
	Хангалтгүй	≤40 %	1-3		
Зам, даваа нээх техник хэрэгслийн бэлэн байдал	Сайн	80 %<	7-10	10	18 сумын хэмжээнд зам даваа нээхэд зориулж дальпуг 1-2 ширхэг хийсэн.
	Дунд	40-80%	4-6		
	Хангалтгүй	≤40 %	1-3		
Эрүүл мэндийн байгууллагын автомашины хүртээмж	Сайн	80 % <	7-10	4	Аймгийн хэмжээнд нийт 51 автомашин эмнэлгийн тусламж үйлчилгээг ард иргэдэд үзүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд /ЭМГ-4, НЭ-10, ЗӨСТ-4, ӨЭМТ-3, СЭМТ-27/.
	Дунд	40-80%	4-6		
	Хангалтгүй	≤40 %	1-3		

Малчин өрхийн ажиллах хүчний хүртээмж	Сайн, 6 хүн ≤	80 %<	10	4	Уламжлалт аргаар буюу бэлчээрийн мал маллаагаар малаа маллаж байна.	
		40-80%	8-9			
		≤40 %	7			
	Дунд, 6-4 хүн	80 %<	6			
		40-80%	5			
		≤40 %	4			
	Муу,≤3 хүн	80 %<	3			
		40-80%	2			
		≤40 %	1			
Малчин өрхийн мэдлэг туршлага	Малчнаар ажиллаж байгаа хугацаа	10 ≤жил	80 % <	10	6	Малчин өрхийн мэдлэг туршлага цаг үеэ даган өөрчлөгдөж ахмад настны туршлага судлахгүй байна.
			40-80%	8-9		
			≤40 %	7		
		3-9 жил	80 % <	6		
			40-80%	5		
			≤40 %	4		
		≤3 жил	80 %<	3		
			40-80%	2		
			≤40 %	1		
Даатгалд хамрагдсан байдал	Малын даатгал	70% <	7-10	7	7	Мал сүргийг байгалийн гамшигт үзэгдэл ган, зудаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2,2 мянган малчин өрхийн 713.3 мянган толгой малыг малын индексжүүлсэн даатгалд хамруулсан байна.
		30-70%	4-6			
		30%>	1-3			
	Эд хөрөнгийн даатгал	70% <	7-10			
		30-70%	4-6			
		30%>	1-3			
Цаг агаарын урьдчилсан мэдээг авах боломж	Сайн	70% <	7-10	7	Олон нийтийн сүлжээ, телевиз, багц мессежээр цаг агаарын урьдчилан сэрэмжлүүлэх, анхааруулах мэдээллийг тогтмол өгч байна. Мөн сумдын багийн дарга нар сүлжээгүй газарт биечлэн хүргэдэг.	
	Дунд	30-70%	4-6			
	Хангалтгүй	30%>	1-3			
Өвс тэжээлийн нөөцийн агуулахын хүрэлцээ	Сайн	70% <	7-10	1	Онцгой байдлын газрын 137 дугаар салбар болон аймгийн аюулгүйн нөөцд л өвж тэжээлийн агуулахтай бөгөөд 18 сумын хэмжээнд өвс тэжээл агуулах хүрэлцээ маш хангалтгүй.	
	Дунд	30-70%	4-6			
	Хангалтгүй	30%>	1-3			
	Сайн	70% <	7-10	10		

Малын гоц халдвар өвчний вакцинжуулалтын хувь	Дунд	30-70%	4-6		Мал, амьтны гоц халдварт Шүлхий өвчөөс урьдчилан сэргийдэх дархлаажуулалт 99,2 хувьтай, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт 99,8 хувьтай хийгдэж дууссан.
	Хангалтгүй	30%>	1-3		
Туулах чадвартай машины хүрэлцээ	Сайн	70% <	7-10	5	СЗДТГ-т 1-2 машин бэлэн байдалд байдаг. Аймгийн хэмжээнд сумдын автомашин судалгааг сар бүр тодотгож ажиллаж байна.
	Дунд	30-70%	4-6		
	Хангалтгүй	30%>	1-3		
Дотоодын болон олон улсын байгууллагын тусламжийг хүлээн авах болон түгээх чадвар	Сайн	70% <	7-10	4	Дотоодын болон олон улсын байгууллагын тусламж үйлчилгээг ард иргэдэд түгээх чадвар сайн
	Дунд	30-70%	4-6		
	Хангалтгүй	30%>	1-3		
Нийт оноо			87.7/19		
Дундаж оноо			4.6		

№	Сумын нэр	Аюулын үнэлгээ (H)	Эмзэг байдлын үнэлгээ (V)	Чадавхын үнэлгээ (C)	Эрсдэлийн үнэлгээ (R)
1	Эрдэнэбулган	7.1	6.7	5.8	8.2
2	Батцэнгэл	7.5	6.5	4.2	11.6
3	Булган	6.7	6.3	4.3	9.8
4	Жаргалант	10	6.7	5.4	12.4
5	Ихтамир	8.2	6	4.3	11.4
6	Өндөр-улаан	8.2	5.6	4.2	10.9
7	Өлзийт	7	5	3	11.6
8	Өгийнуур	5.3	5.8	3	10.2
9	Тариат	8.1	7.3	4.9	12.1
10	Төвшрүүлэх	7.2	8.2	5.3	11.1
11	Хангай	6.9	6.7	4.4	10.5
12	Хашаат	8.9	6.4	6.5	8.7
13	Хайрхан	6.9	7.4	4.9	10.4
14	Хотонт	6.8	6.3	4.6	9.3
15	Цахир	7.2	6.8	4.3	11.3
16	Цэцэрлэг	5.8	5.8	4.7	7.1
17	Цэнхэр	6.8	6.5	4.5	9.8
18	Чулуут	6.5	6.3	4.8	8.5
19	Эрдэнэмандал	7.2	6.7	4.3	11.2

Сумдын зудын эрсдэлийн үнэлгээний нэгтгэл
Зудын эрсдэлийн (Зудын эрсдэлийн тоон утга)

Аюулын үнэлгээ (H)	Эмзэг байдлын үнэлгээ (V)	Чадавхын үнэлгээ (C)	Эрсдэлийн үнэлгээ (R)
8.2	5.7	4.6	10.1

ЗУДЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ДҮГНЭЛТ

Архангай аймгийн 19 сумын хэмжээнд зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээг зохион байгуулахад Батцэнгэл, Жаргалант, Ихтамир, Өндөр-Улаан, Өлзийт, Өгийнуур, Тариат, Төвшрүүлэх, Хангай, Хайрхан, Цахир, Эрдэнэмандал сумдууд нэн их эрсдэлтэй, Эрдэнэбулган, Булган, Хашаат, Хотонт, Цэцэрлэг, Цэнхэр, Чулуут сумдууд их эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Архангай аймгийн зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээнд үндэслэн зудын эрсдэлийг бууруулах дараах зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үүнд:

1. Сумдын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн тоог нэмэгдүүлэх
2. Зудын үед хүн ам, мал, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх зам маршрут, байрлах газар нутгийн хувилбарыг сонгох, бэлтгэх, нутаг дэвсгэрийг зураглалд оруулах
3. Отор нүүдэлээр яваа болон өвөлжилт хүндрэх газрын айл өрхүүд хоол хүнс, дулаан хувцас, түлш түлээ, эм тариаг бэлэн байдалд цаг үргэлж анхаарч ажиллах
4. Сумын Засаг дарга болон Багийн дарга нарыг иргэдэд урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллах